

**УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ
ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот 2023 он

УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Тусгагдсан зохицуулалттай уялдан зардал үүсгэх болон үүсгэж болзошгүй зүйл, заалтыг Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу судлалаа.

ХОЁР. УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР

Хуулийн төслөөр иргэдэд шинээр үүрэг гүйцэтгэхийг даалгаагүй, хуучин хуулийн хэрэгжилтийн хүрээнд байх бөгөөд шинээр гадаадад амьдарч буй иргэдиг саналаа өгөх боломжоор хангаж өгсөн билээ. Иймд гадаадад амьдарч буй иргэд санал өгөхтэй холбоотойгоор нэмэлт зардлууд үүснэ.

Амьдран буй байршил, элчин сайдын яамны оршин байх хотоос хамаарч санал өгөх өдөрт нэг иргэн санал өгөх байранд очиж, буцаж ирэх бөгөөд дунджаар 4 цагийг зарцуулна гэж тооцож байна. Иймээс нэг иргэний санал өгөх байранд очиж, буцаж ирэх зардал нь дунджаар $30\$ /30 \times 3526 = 105,780$ төгрөг/ байна гэж тооцож байна. 2012 онд 3,700 хүн санал өгөхөөр бүртгүүлснээс 2,700 иргэн саналаа өгч байсан. Ирэх онд 10,000 иргэн саналаа өгөхөөр бүртгүүлж, үүнээс 7,000 иргэн саналаа өгнө гэж тооцож байна. Иймээс гадаадад амьдарч буй иргэд саналаа өгөхтэй холбоотойгоор 740,460,000 төгрөгийн нэмэлт зардал гадаадад амьдарч буй иргэдэд гарна гэж тооцож байна.

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНААР АЖ АХУЙН НЭГЖИД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР

Хуулийн төслөөр аж ахуйн нэгжүүдэд шинээр үүрэг гүйцэтгэхийг даалгаагүй байх тул зардал үүсгэх зохицуулалт байхгүй байна.

Иймд аргачлалд заасны дагуу цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй бөгөөд Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь аж ахуйн нэгжүүдэд нэмэлт зардал үүсгэхгүй гэж үзэж байна.

ДӨРӨВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ТӨРД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн дагуу төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг тооцооллоо.

Хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор Сонгуулийн Ерөнхий хорооноос холбогдох журмуудыг шинэчлэн батлах, өөрчлөн батлах, сонгуулийн автоматжуулсан системд нэмэлт тохиргоо, өөрчлөлт хийх, баталгаажуулах, намд өгсөн саналыг хувьчлан хуваарилах гэх зэрэг ажилбарууд шинээр үүснэ. Эдгээр бүлэг ажилбаруудыг гүйцэтгэхэд нийт 4,000 хүн цагийн зардал үүснэ гэж үзвэл Сонгуулийн ерөнхий хороонд нэмэлтээр үүсэх зардал нь 10,9 сая төгрөг болно.

Мөн гадаадад буй элчин сайдын яамдуудад санал өгөх сонгогчдын нэрсийн жагсаалтыг гаргах, тулгах, санал авах байрыг бэлдэх, зохион байгуулалтаар хангах болон санал авах өдрийн үйл ажиллагаатай холбоотой нэмэлт зардлууд үүснэ. Ажиллан буй улсын амьдран суугаа иргэдийн тоо, улсын газар нутгийн хэмжээ, амьдралын өртгөөс хамааран эдгээр зардлууд нь ялгаатай байх боловч нэг элчийн сайдын яаманд 4,000 хүн цагийн зардал үүснэ гэж үзэж байна. Энэ нөхцөлд нэг элчин сайдын яаманд 10,9 сая төгрөгийн нэмэлт зардал үүсэхээр тооцож байна.